



South Gobi Energy Resources

Саутгоби Энержи Ресурс компани нь TSX хөрөнгийн бирж дээр SGQ нэрээр бүртгэгдсэн компани юм.

Саутгоби Энержи Ресурс компани Пермийн үеийн металлургийн болон дулаан ялгаруулах нүүрсний ордуудыг Монголын говийн бүсэд хайж илрүүлэн хөгжүүлснээр Монгол болон Хятад улсын олон төрлийн нүүрсэн бүтээгдэхүүн болон эрчим хүчийг нийлүүлэх боломжтой болно. Овоот Толгой бол компанийн хамгийн дэвшилттэй нүүрсний уурхай байгуулах төсөл юм. Овоот Толгой нь Монгол орны өмнөд хэсэгт одоогийн МАК/Синхуа нүүрсний уурхайн зэргэлдээ, Монгол/Хятадын хилээс хойд зүгт ойролцоогоор 45 км-т оршдог. Саутгоби Энержи Ресурс компани Овоот Толгойд нүүрсний ил уурхайн тусгай зөвшөөрлийг хүлээж авсан.

Тус компани нь бүх хувьцаа эзэмшигчдийнхээ ашгийн төлөө нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцид орчин үеийн нүүрс цэвэршүүлэх техник технологийг нэвтрүүлэхээр судалгааны ажилдаа ороод байна.

Саутгоби Энержи Ресурс компанийн Металлийн салбар Монгол болон Индонези улсад зэс алтны ордуудыг хайж илрүүлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх газраас Саутгоби Энержи Ресурс компанийн салбар компани болох Саутгоби Сэнд ХХК –ийг “ 2007 оны Шилдэг Хайгуулын Компани” гэж өргөмжилсөн.

Компанийн нүүрсний нөөцөд Овоот Толгойн нүүрсний ил уурхайгаас гадна хайгуулын 5 төслүүд багтсан байгаа. . Одоогийн байдлаар Овоот Толгойд хийсэн хайгуулын ажлын үр дүнд 150 сая тонн нүүрсний нөөцийг тогтоогоод байгаа ба үүн дээр нэмж 29 сая тонн нөөцийг тогтоох шинжилгээ судалгааны ажил явагдаж байна.

Хамрах нутаг	ASTM Групп	Ордын нөөц тонноор		
		Хэмжигдс Эн	Тогтоогдс он	Шинжилгээнд оруулсан
Зүүн урд талбай	hVВ аас hVА хүртэл	49,752,000	15,987,000	6,502,000
Баруун талбай	mHВ аас хүртэл hVА	55,144,000	28,698,000	22,601,000
Нийт		149,580,000		29,103,000

Овоот Толгой нүүрсний ил уурхайн анхан шатны үйл ажиллагааг 2008 оны эхний улиралд эхлүүлэхээр мөн нүүрсийг Овоот Толгойгоос зах зээлд нийлүүлэн тээвэрлэх ажил 2008 оны гуравдугаар улиралд эхлэхээр төлөвлөгдөж байна. Үйлдвэрлэл явуулж эхлүүлэх хөрөнгийн зардлыг ойролцоогоор 45 сая ам доллар гэж тооцоолсон. Саутгоби саяхан гаргасан мэдээндээ нүүрсний уурхайн тоног төхөөрөмжүүд худалдан авсанаа мэдэгдсэн ба 2007 оны 12 –р сард туслах тоног төхөөрөмжүүд болон түр хугацааны сэргээн босгох төхөөрөмжүүдийг Овоот Толгойн уурхайн талбарт аваачсан. Бусад тоног төхөөрөмжүүд нь ирэх долоо хоногуудаас ирэхээр төлөвлөгдөж байна.

Саутгоби нийт 117.9 сая канад доллартай тэнцэх 3 удаагийн шууд хөрөнгө оруулалттай санхүүжилтийг 2008 оны нэг, хоёрдугаар саруудад хийж гүйцэтгэсэн.

Айванхоу Майнз компани нь Саутгоби Энержи Ресурс компанийн толгой компани бөгөөд Австралийн Мелбурн, Английн Лондон хотуудад байрладаг Рио Тинто компанитай өнгөрсөн 10-р сард түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж Монгол Хятадын хилээс 80 км зайтай байрладаг, Айванхоу Майнзийн дэлхийн жишигт хүрсэн зэс алтны Оюу Толгой орд газрыг ашиглах, хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна.